

8-Р САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВЛДУУДААС....

Шарга сум.

ШАРГЫН ХУРД-2017 НААДАМ БОЛЛОО

Сумын МСУХ-той хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Шаргын хурд-2017 наадам энэ жил Баянгол багт энэ сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан байна. Багуудад ээлжлэн уг наадмыг зохион байгуулдаг байгаа. Наадамд 6 насны морь уралдсан. Наадмыг TV-9 телевизээр дамжуулан үзэгч түмэндээ толилуулсан байна.

АЙМГИЙН АРСЛАН Э.ДАВААЖАРГАЛЫН ЦОЛНЫ

МЯЛААЛГА НААДАМ БОЛЛОО

Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадамд Налайх дүүрэгт түрүүлж аймгийн арслан цол хүртсэн Шарга сумын уугуул Эрдэнэцогтын Даваажаргалын арслан цолны мялаалга наадам энэ сарын 07-ны өдөр боллоо. Наадмаар 2 насны морь уралдаж бөхийн барилдаан болсон байна. Э.Даваажаргал нь 15 жилийн дараа тус сумаас төрж байгаа арслан юм. Мөн энэ жил Б.Төрмөнх, Э.Өвгөнхүү нар аймгийн начин цол хүртсэн байна.

ХАДЛАН БЭЛТГЭХ АЖИЛ ЯВАГДАЖ БАЙНА

Сумын хэмжээнд аймгийн тусгай хэрэгцээний газар болох 1800 га хадлангийн талбайтай. Энэ жил хадлангийн 3 салаа, 2 багийн хадлангийн бригад гарч нийтдээ 18 техник, 40 гаруй хүн ажиллаж одоогийн байдлаар 1200тн хадланг бэлтгэж сум багийн иргэд малчдад хүргээд байна. Сумын өвч тэжээлийн аюулгүйн нөөцөд 50тн өвсийг нөөцлөөд байна.

ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ АСУУЛГА ЯВАГДЛАА

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал асуулгыг багуудын иргэдээс авч нэгтгэн хүргүүллээ. Судалгаанд 250 иргэн хамрагдсан байна.

УСНЫ ТООЛЛОГО ЯВАГДЛАА

Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүйсийн говь-цэцэг нуурын сав газартай хамтран уст цэгийн тооллогын ажлыг зохион байгууллаа.

БЭЛЧЭЭРИЙН УРГАЦЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АЖИЛ ХИЙГДЛЭЭ

Сумын бэлчээрийн даац багтаамжийг тодрхойлох, бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг хянах, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах зорилгоор бэлчээрийн ургамлын хэмжилтийн ажил 8 сарын 1-10-ны хооронд явагдлаа. Сумын Засаг даргын 2017 оны А\41 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж 4 багийн 14 цэгээс ургацын дээж авч үнэллээ. Бэлчээрийн даац сумын түвшинд хэтэрсэн, ургацын үнэлэмж 0 хувьтай, нийт нутгаар гантай байна.

УНДНЫ ХУДГИЙН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ХИЙГДЛЭЭ.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Ногоон хөгжил-Цэмцгэр Шарга” хөтөлбөрийн хүрээнд ундны худгийг засварлах тохижуулах ажлыг 2480.000 төгрөгийн хөрөнгөөр хийлээ. Уг ажлаар ундны худагт эрүүл ахуйн бүс тогтоож хайсжуулах, гадны байрыг засварлах, цэцэрлэгт хүрээлэнгийн услалтын системийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийсэн байна.

Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг